

Хил хамгаалах ерөнхий газар

**ХИЛИЙН БООМТ БОЛОН МОНГОЛ-ОРОСЫН
УЛСЫН ХИЛИЙГ ХЯЛБАРЧИЛСАН ЖУРМААР
НЭВТРЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

**МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛИЙН БООМТ,
ТЭДГЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР, БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Улаанбаатар хот
2022 он

**ХИЛИЙН БООМТ БОЛОН МОНГОЛ-ОРОСЫН УЛСЫН
ХИЛИЙГ ХЯЛБАРЧИЛСАН ЖУРМААР НЭВТРЭХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**
(Улаанбаатар хот, 1994.08.10)

(Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан хувилбар)

ХИЛИЙН БООМТ БОЛОН МОНГОЛ-ОРОСЫН УЛСЫН ХИЛИЙГ ХЯЛБАРЧИЛСАН ЖУРМААР НЭВТРЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар (цаашид “Талууд” гэх),

Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрийн 16 дугаар зүйлийн дагуу,

Эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан цаашид найрсаг хөршийн найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг улам бэхжүүлэн, хөгжүүлэх зорилгоор,

Хилийн боомтын нэвтрүүлэх чадавхыг нэмэгдүүлэх, иргэд, тээврийн хэрэгсэл болон бараа бүтээгдэхүүний нэвтрэх зохих нөхцөлийг бүрдүүлэхийг эрмэлзэж,

Дараах зүйлийг харилцан тохиролцов:

(Хэлэлцээрийн энэ хэсгийг Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

Нэгдүгээр зүйл

Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт дараах өөрчлөлтийг оруулах:

(Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийг Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

Хоёрдугаар зүйл

1.Хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг энэхүү Хэлэлцээр болон монгол-оросын улсын хилийг нэвтрэх журмыг тодорхойлсон бусад гэрээ мөн Талуудын хууль тогтоомжийн дагуу нэвтрүүлнэ.

2.Талууд хилийн боомтын хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай

байр сууц, дэд бүтцийг бий болгоно.

3.Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт хилийн боомтын дэд бүтцийг бүрдүүлэх болон төхөөрөмжлөн тохижуулахдаа зорчигчдын урсгалын өсөлт, түүний дотор явган зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа хилээр нэвтрэх хэтийн төлвийг харгалзан үзэж байна.

4.Талуудын эрх бүхий байгууллагууд хилийн боомтын барилга байгууламжийн төслийг бэлтгэх, түүнийг хэрэгжүүлэх ажлын явц, түүнчлэн эдгээр байгууламжийг барьж дуусгах хугацааны талаар зөвлөлдөж байна.

5.Талуудын эрх бүхий байгууллагууд хилээр нэвтрэх явдлыг боловсронгуй болгох, хилийн боомтыг зүй зохистой ашиглах асуудлаар хамтран ажиллана.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхдээ энэхүү зүйлийн 2, 3, 4 дүгээр заалтыг мөрдлөг болгоно.

Гуравдугаар зүйл

1.Хилийн боомт шинээр нээх, хаах болон тэдгээрийн ангилал өөрчлөхийг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр ноот бичиг солилцох замаар дипломат шугамаар буюу өөр тохиромжтой хэлбэрээр хийнэ.

2.Талуудын хууль тогтоомжийн дагуу хилийн боомтын барилгын ажил (засвар), тохижилт, техник хангамж, тээвэрлэлт, инженер болон нийгэм-ахуйн дэд бүтцийн ажлыг хийж дууссаны дараа хилийн боомтыг нээнэ.

(Хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

Дөрөвдүгээр зүйл

Олон улсын нээлттэй нисэх буудал, далай боомтоор Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд харилцан зорчих, олон улсын шуудан харилцааны газар цэгүүдээр шуудан илгээлт солилцох ажлыг энэхүү Хэлэлцээрийг байгуулагч Талуудын оролцож буй олон улсын хоёр болон олон талын хэлэлцээрүүдийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.

Тавдугаар зүйл

1.Эрүүл ахуйн шаардлага, нийгмийн аюулгүй байдлын үүднээс болон байгалийн гамшгийн улмаас хилийн зарим боомтоор хил нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох буюу хязгаарлаж болно. Хил нэвтрэх хөдөлгөөнийг

зогсоох буюу хязгаарлахаар төлөвлөж буй тал энэ тухайгаа тухайн боомтод хөдөлгөөнийг зогсоох буюу хязгаарлахаас 5-аас доошгүй хоногийн өмнө нөгөө Талдаа мэдэгдэнэ. Хойшлуулшгүй тохиолдолд хил нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох буюу хязгаарлахаар төлөвлөж буй хугацаанаас 24 цагийн өмнө мэдэгдэнэ.

2.Хилийн боомтын барилга, шугам сүлжээ инженерийн байгууламжийн засвар үйлчилгээтэй холбогдон хил нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох буюу хязгаарлах тухайгаа засварын ажил эхлэхээс 3 сарын өмнө засварыг дуусгахаар төлөвлөж буй хугацааны хамт Талууд бие биедээ мэдээлнэ.

3.Талууд улсын хил нэвтрэх хөдөлгөөнийг зогсоосон буюу хязгаарласныг цуцалсан талаар цаг тухайд нь дипломат шугамаар харилцан мэдээлнэ.

(Хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

Зургадугаар зүйл

Талууд эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрсдийн хууль тогтоомжийн дагуу зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн боомтоор ийнхүү хил нэвтрэхийг заагаагүй байсан нь тусгайлан үзэж уг боомтоор хил нэвтрүүлэхийг зөвшөөрч болно.

Долдугаар зүйл

Талуудын хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугчдын ашиг сонирхлыг харгалзан энэхүү Хэлэлцээрээр тодорхойлсон нөхцөлийн дагуу хил нэвтрэх хялбарчилсан журмыг тогтоож байна.

Хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх хилийн тусгай боомтын жагсаалтыг энэхүү Хэлэлцээрийн хавсралт №2-т тодорхойлов.

Энэ зорилгоор хавсралт №1-д заагдсан хилийн боомтуудыг мөн ашиглаж болно.

Наймдугаар зүйл

Хялбарчилсан журмаар нэвтрэх хилийн боомтыг төхөөрөмжлөн тохижуулах, зохих дэд бүтцийг бүрдүүлэх, түүнчлэн эл зорилгоор шинээр хилийн боомт нээх ашиглагдаж байсан боомтыг хаах асуудлыг шийдвэрлэхдээ энэхүү Хэлэлцээрийн 2, 3 дугаар зүйлийн заалтуудыг мөрдлөг болгоно.

Есдүгээр зүйл

Хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх боомтуудад Талууд хил,

гаалийн алба, шаардлагатай нөхцөлд хяналтын бусад албыг тогтмол ажиллуулах бөгөөд тэдгээр нь энэхүү Хэлэлцээрийн заалтууд, бусад хүчин төгөлдөр хоёр талын гэрээ, хэлэлцээрүүд, түүнчлэн Талуудын дотоодын хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллана. Талууд энэ талаарх дотоодын хууль тогтоомж өөрчлөгдсөн тухайд даруй харилцан мэдээлж байна.

Аравдугаар зүйл

1.Монгол Улс Оросын Холбооны Улсын дор дурдсан иргэд хил орчмын районд зорчихдоо хүчин төгөлдөр хувийн бичиг баримт болон улсын хилийг хялбарчилсан журмаар нэг удаа цааш нааш нэвтрэх үнэмлэхээр нэвтэрч байна. Хувийн бичиг баримтад үндэсний дотоод, гадаад паспорт, албан, дипломат паспорт, цэргийн албан хаагчийн хувийн үнэмлэх, түүнчлэн эх орондоо буцаж явааг нотлох албан бичиг орно.

2.Монгол-Оросын улсын хилийн хялбарчилсан журмаар нэг удаа нэвтрэх үнэмлэхийг монгол, орос хэлээр үйлдэх бөгөөд Талуудын эрх бүхий байгууллагуудаас олгоно. Энэхүү Хэлэлцээрт дурдсан эрх бүхий байгууллагуудад:

а/ Монголын талаас - Монгол Улсын бүртгэлийн ерөнхий газрын орон нутгийн байгууллагууд;

(Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 2 дугаар дахь хэсгийн "а"-г Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

б/Оросын талаас Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны орон нутгийн байгууллагууд орно.

Энэхүү Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн 2-ын "в", "ж"-д заасны дагуу хил нэвтрэх хоёр талын иргэдэд Талуудын Хилийн Бүрэн Эрхт Төлөөлөгч үнэмлэх олгож болно. Үнэмлэхүүдийн загварыг Хэлэлцээрийн хавсралт №3-т тодорхойлов.

3.16 нас хүрээгүй хүүхдийг дагалдан яваа дээрх үнэмлэх авах эрх бүхий төрөл төрөгсөд болон бусад насанд хүрсэн итгэмжлэгдсэн хүнд олгосон үнэмлэхэнд нэрийг бичсэнийг үндэслэн хил нэвтрүүлнэ.

Энэхүү заалт нь уг Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн 2-ын "г"-д заасан сургуульд явах хүүхдэд хамаарахгүй.

4.Улсын хилийг нэг удаа нэвтрэх үнэмлэхээр нөгөө Талын нутагт ирж байгаа Монгол Улс, Оросын Холбооны Улсын иргэд үнэмлэхэнд нь заасан хил орчмын нутаг дэвсгэрийн хязгаар дотор зорчих бөгөөд хэрэв бүртгүүлэх журамтай байвал биелүүлэх үүрэгтэй.

5.Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хил орчмын нутаг дэвсгэр

гэдэгт Монгол Улс Оросын Холбооны Улсын хил залгаа орших засаг захиргааны нэгжүүд орно. Оршин суугчдад нь Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх эрх олгогдсон Монгол Улс, Оросын Холбооны Улсын засаг захиргааны хил орчмын нэгжийн жагсаалтыг энэхүү Хэлэлцээрийн хавсралт №4-т тодорхойлов.

6.Энэхүү Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн 2-ын "ж"-д заасны дагуу нөгөө Талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх иргэд, тээврийн хэрэгсэлд зөвхөн үнэмлэхэнд заасан чиглэлээр явахыг зөвшөөрнө.

7.Улсын хилийг нэвтрэх зорилгыг харгалзан зорчигчдын нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацааг тогтооно. Ингэхдээ үнэмлэхийн хүчинтэй байх хугацаа 90 хоногоос илүүгүй байна.

8.Үнэмлэхээ нөгөө Талын нутаг дэвсгэрт үрэгдүүлсэн тохиолдолд эзэмшигч тухайн улсын орон нутгийн эрх бүхий байгууллагад даруй мэдэгдэж, тэндээс үнэмлэхээ үрэгдүүлснийг нотолсон бичиг авч улсын хилийг нэвтрэнэ. Энэхүү бичгийн загварыг Талуудын эрх бүхий байгууллагууд хоорондоо тохиролцоно.

Арван нэгдүгээр зүйл

Улсын хилийг нэг удаа нэвтрэх үнэмлэхийг иргэдэд дараах тохиолдолд олгоно.Үүнд:

1.Хоёр улсын хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэдэд;

а/зан үйл, ёслол (хурим хийх, хүүхэд төрөх, оршуулга гэх мэт) болох үеэр төрөл садантайгаа уулзах;

Энэхүү Хэлэлцээрт дурдсан төрөл саданд: эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, нөхөр, эхнэр, эмэг эх, өвөг эцэг, элэнц эх, элэнц эцэг, хүргэн, бэр, хадам эцэг, хадам эх (зээ), гуч (зээнцэр) багтана.

б/Өөрийн улсын нутаг дэвсгэрт эмнэлгийн яаралтай тусламж авч чадахгүй тохиолдолд өвчтөн буюу түүний дагалдан яваа хүмүүст;

в/Хүндээр өвчилсөн буюу гэнэтийн осолд өртсөн төрөл садангаа эргэх;

г/Алтанбулаг, Хиагт хот дахь Монголын ардын хувьсгалын газруудыг зохион байгуулалттайгаар үзэх;

д/Төрөл саднаа оршуулсан газарт очих.

2.Хоёр улсын хил орчмын нутаг болон түүний хязгаарын гадна оршин суудаг иргэдэд;

а/Улсын хил дээр буюу хил орчмын нутагт орон нутгийн засаг захиргааны тохиролцоогоор зохиогдож байгаа олон нийтийн хамтарсан арга хэмжээнд уригдсан хүмүүс;

б/Талууд хэлэлцэн тохирсны үндсэн дээр хил орчмын нутагт эрдэм шинжилгээ, худалдаа, тээвэр, аж ахуйн үйл ажиллагаа явуулах буюу байгаль орчны байдалд хяналт тавих хүмүүс;

в/Хил гаалийн болон хилийн боомтын хяналтын бусад албаны төлөөлөгчид, энэхүү Хэлэлцээр, мөн хилийн асуудлаар Талуудын хооронд байгуулсан бусад гэрээ, хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа явуулж буй албан байгууллагын ажилтнууд;

г/Нөгөө талын хил орчмын нутагт орших сургуульд суралцагсад;

д/Байгалийн гамшиг буюу бусад онцгой нөхцөл байдал, тухайлбал, хүн мал, тэжээвэр болон зэрлэг амьтдын гоц халдварт өвчин, хөдөө аж ахуйн таримал болон бэлчээрийн ургамлын хортон их хэмжээгээр тархах зэрэгтэй тэмцэхэд нөгөө Талын хил орчмын нутгийн засаг захиргаа, оршин суугчдад тусалцаа үзүүлэхээр яваа хүмүүс;

е/Талуудын аль нэгний эмнэлгийн байгууллага өөрсдийн хүчээр эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж чадахгүй нөхцөлд өвчтөнд (осолдогчид) яаралтай тусламж үзүүлэхээр хил нэвтэрч яваа эмнэлгийн ажилтан;

ж/Өөрийн нутгаар хүрэхэд бэрхшээлтэй газарт очихын тулд нөгөө Талын нутгаар дамжин өнгөрөх хүмүүс;

3.Энэхүү зүйлийн 2-ын “б”, “в”, “г”, “ж”-д заасны дагуу улсын хил нэвтрэхээр яваа Талуудын иргэдэд зайлшгүй шаардлагатай нөхцөлд хилийг цааш нааш олон удаа нэвтрэх журмыг Талуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцэн тохиролцоно.

4.Хил нэвтрэх үнэмлэх олгох үндэслэлийг Талуудын эрх бүхий байгууллагууд жич тохиролцоно.

Арван хоёрдугаар зүйл

Хялбарчилсан журмаар хил нэвтрэх авто тээврийн хэрэгслийн жолооч нар энэхүү Хэлэлцээрийн 10 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр үндэсний паспорт буюу бусад хувийн бичиг баримтаас гадна жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн даатгал, техникийн байдлыг тодорхойлсон баримт бичгийг биедээ авч явах үүрэг хүлээнэ.

Арван гуравдугаар зүйл

1.Хил орчмын нутагт байгалийн гамшиг буюу энэхүү Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн 2-ын “д”, “е”-д дурдсан бусад онцгой нөхцөл байдал тохиолдсон үед түүнтэй тэмцэхэд шуурхай тусламж үзүүлэхээр дайчлагдсан хүмүүсийг онцгойлон үзэж Хилийн Бүрэн Эрхт Төлөөлөгчид буюу тэдний орлогчдын харилцан тохиролцсоноор Хэлэлцээрт заасан боомтоор өөр газраар хоногийн аль ч үед үндэсний дотоод паспорт, түүнийг орлох баримт бичгээр хил нэвтрүүлж болох бөгөөд дараа нь Хилийн Бүрэн Эрхт Төлөөлөгчид хил нэвтэрснийг хоёр талын актаар бүртгэж байна.

2.Шаардлага тохиолдсон үед Талуудын Хилийн Бүрэн Эрхт

Төлөөлөгчид харилцан тохиролцож, дээр дурдсан зорилгоор тухайн онцгой нөхцөлд түр хугацаанд яаралтай нэвтрүүлэх боомт нээж ажиллуулах эрхтэй байна.

3.Үүний зэрэгцээ дээр дурдсан нөхцөлд Талууд тухайн нутаг дэвсгэрт байрладаг хилийн бусад боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхийг бүрэн зогсоох буюу хэсэгчлэн хязгаарлаж болно.

4.Талууд улсын хилээр хялбарчилсан журмаар нэвтрэхийг түр зогсоосон буюу хязгаарласан, дахин сэргээсэн тухай даруй харилцан мэдээлж байх бөгөөд онцгой нөхцөл байдлын уршиг, үр дагаврыг арилгахаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнгийн талаар тогтмол мэдээлж байх үүргийг хүлээнэ.

Арван дөрөвдүгээр зүйл

1.Хоёр Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа тухайн орны хууль тогтоомжийг чандлан сахих, ёс заншлыг нь хүндэтгэх, хүрээлэн байгаа орчныг хамгаалах талаар тогтоосон журмыг биелүүлэх.

2.Энэхүү Хэлэлцээрийн заалтыг зөрчсөн хүмүүс нь цаашид нөгөө Талын нутаг дэвсгэрт байх эрхээ алдаж болно. Зөрчлийн байдлаас шалтгаалан тэдгээр хүмүүсийн тухайн улсын нутаг дэвсгэрт дахин орох эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах буюу уг улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлагад татаж болно.

Арван тавдугаар зүйл

Хилийн боомтын ажиллах журам, түүнчлэн энэхүү Хэлэлцээрт тусгагдаагүй бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаатай холбоо бүхий бусад техник-зохион байгуулалтын асуудлуудыг Талуудын Хилийн Бүрэн Эрхт Төлөөлөгчид харилцан тохиролцож байх бөгөөд шаардлагатай нөхцөлд хяналтын бусад байгууллагуудтай зөвшилцөж байна

Арван зургадугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт дипломат шугамаар тохиролцож нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд Тал тус бүрийн дотоод журмын дагуу батлагдсаны дараа тэдгээр нь хүчин төгөлдөр болно.

Талууд энэхүү хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэгжүүлэхэд гарч болох маргаан болон зөрүүтэй саналыг хэлэлцээ хийх болон зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

(Хэлэлцээрийн 16 дугаар зүйлд Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

Арван долдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1986 оны 1 дүгээр сарын 25-нд байгуулсан “Хил орчмын районд оршин суугаа БНМАУ, ЗСБНХУ-ын иргэд улсын хилийг нэвтрэх хялбарчилсан журмын тухай Бүгд найрамдах Монгол ард Улсын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр”-ийг хүчингүй болсонд тооцно.

Арван наймдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж таван жилийн хугацаанд үйлчлэх бөгөөд аль нэг Тал нь энэхүү Хэлэлцээрийн хугацаа дуусахаас 6 сарын өмнө түүнийг цуцлах тухай саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдээгүй бол хүчинтэй байх хугацаа нь тав таван жилээр аяндаа сунгагдаж байх болно.

Хэлэлцээрийг 1994 оны наймдугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ӨМНӨӨС
Ж.ЧОЙНХОР

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС
ПАНОВ.А.Н

”Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрийн **ХАВСРАЛТ 1**

(Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулсан Протоколын найруулгаар)

МОНГОЛ-ОРОСЫН УЛСЫН ХИЛИЙН БООМТУУДЫН НЭР, АНГИЛАЛ, БАЙРШИЛ

I. Олон улс /олон талт/-ын зэрэглэлтэй хилийн боомт:

1. Сүхбаатар (Монгол Улс) - Наушки (Оросын Холбооны Улс).

Энэхүү олон улс /олон талт/-ын зэрэглэлтэй, төмөр замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 633 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Наушки боомтын хоёр талд оршино.

2. Алтанбулаг (Монгол Улс) - Хиагт (Оросын Холбооны Улс).

Энэхүү олон улс /олон талт/-ын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 652 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Хиагт боомтын хоёр талд оршино.

3. Цагааннуур (Монгол Улс) - Ташанта (Оросын Холбооны Улс).

Энэхүү олон улс /олон талт/-ын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 54 дүгээр тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Цагааннуур тосгон, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Алтай Улсын Ташанта боомтын хоёр талд оршино.

4. Эрээнцав (Монгол Улс) - Соловьевск (Оросын Холбооны Улс).

Энэхүү олон улс /олон талт/-ын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 938 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорнод аймгийн Чулуунхороот сум, Оросын Холбооны Улсын Өвөр байгалийн хязгаарын Соловьевск тосгон боомтын хоёр талд оршино.

5. Боршоо (Монгол Улс) - Хандгайт (Оросын Холбооны Улс).

Энэхүү олон улс /олон талт/-ын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 126 дугаар

тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Увс аймгийн Давст сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тыва Улсын Хандгайт тосгон боомтын хоёр талд оршино.

6. Ханх (Монгол Улс) - Монд (Оросын Холбооны Улс).

Энэхүү олон улс /олон талт/-ын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын улсын хилийн 378 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Хөвсгөл аймгийн Ханх сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Монд тосгон боомтын хоёр талд оршино.

II. Хоёр талын зэрэглэлтэй хилийн боомт:

1.Эрэнцав (Монгол Улс) - Соловьевск (Оросын Холбооны Улс).

Энэхүү хоёр талын зэрэглэлтэй, төмөр замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 938 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорнод аймгийн Чулуунхороот сум, Оросын Холбооны Улсын Өвөр байгалийн хязгаарын Соловьевск тосгон боомтын хоёр талд оршино.

2.Арц суурь (Монгол Улс) - Цагаантолгой (Оросын Холбооны Улс).

Энэхүү хоёр талын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 244 дүгээр тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Завхан аймгийн Тэс сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тыва Улсын Эрзин тосгон боомтын хоёр талд оршино.

3.Тэс (Монгол Улс) - Шарсуурь (Оросын Холбооны Улс).

Энэхүү хоёр талын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 200 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Увс аймгийн Тэс сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тыва Улсын Ак-Эрик тосгон боомтын хоёр талд оршино.

4.Бага Илэнх гол (Монгол Улс) - Айнек гол (Оросын Холбооны Улс).

Энэхүү хоёр талын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 487 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Булган аймгийн Тэшиг сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Нуурт тосгон боомтын хоёр талд оршино.

5.Зэлтэр (Монгол Улс) - Желтура (Оросын Холбооны Улс).

Энэхүү хоёр талын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 583 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Түшиг сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Желтура тосгон боомтын хоёр талд оршино.

6:Ульхан (Монгол Улс) - Дээд Ульхан (Оросын Холбооны Улс).

Энэхүү хоёр талын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 840 дүгээр тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорнод аймгийн Баян-Уул сум, Оросын Холбооны Улсын Өвөр байгалийн хязгаарын Дээд Ульхан тосгон боомтын хоёр талд оршино.

7.Агацын гол (Монгол Улс) - Алтан (Оросын Холбооны Улс).

Энэхүү хоёр талын зэрэглэлтэй, авто замын ачаа болон зорчигч тээврийн боомт нь Монгол-Оросын хилийн 815 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Хэнтий аймгийн Дадал сум, Оросын Холбооны Улсын Өвөр байгалийн хязгаарын Алтан суурин газар боомтын хоёр талд оршино.

"Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрийн ХАВСРАЛТ 2

(Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулсан Протоколын найруулгаар)

МОНГОЛ-ОРОСЫН УЛСЫН ХИЛИЙГ ХЯЛБАРЧИЛСАН ЖУРМААР НЭВТРЭХ ХИЛИЙН АВТО ЗАМЫН БООМТЫН ЖАГСААЛТ

I. Түр эсхүл улирлын ажиллагаатай хилийн боомт:

Тогтор (Монгол Улс) - Өвөр тогтор (Оросын Холбооны Улс).

Энэхүү боомт нь Монгол-Оросын хилийн 882 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Дорнод аймгийн Баяндун сум, Оросын Холбооны Улсын Өвөр байгалийн хязгаарын Акшинский бүс боомтын хоёр талд оршино.

II. Тогтмол бүс ажиллагаатай дамжин өнгөрөх хилийн боомт:

1. Асгатын гол (Монгол Улс) - Аспайты (Оросын Холбооны Улс).

Энэхүү боомт нь Монгол-Оросын хилийн 71 дүгээр тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тыва Улсын Мөнгөн тайга хошуу боомтын хоёр талд оршино.

2. Харигийн гол (Монгол Улс) - Мугур-Аксы (Оросын Холбооны Улс).

Энэхүү боомт нь Монгол-Оросын хилийн 96 дугаар тэмдгийн орчимд байна. Монгол Улсын Увс аймгийн Сагил сум, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тыва Улсын Мөнгөн тайга хошуу боомтын хоёр талд оршино.

УДОСТОВЕРЕНИЕ

На разовое пересечение Российско-Монгольской
государственной границы в обе стороны

**Орос-Монголын улсын хилийг нааш цааш нэг
удаа нэвтрэх эрхийн үнэмлэх**

Имя отчество фамилия _____
Овог нэр _____

Местожительство в Российской Федерации _____
ОХУ-д оршин суугаа хаяг _____

Дата рождения _____
Төрсөн он, сар, өдөр _____

Серия, номер, документа, удостоверяющего Личность _____
Паспорт баримт бичгийн сери, дугаар _____

Цель поездки
Явах зорилго

Служебная, частная
Албаны, хувийн

Вид транспорта, регистрационный номер транспортного
средства _____
Уналгын төрөл, тээврийн хэрэгслийн регистрийн дугаар _____

Пункт пересечения российско-монгольской государственной границы (при
выезде и въезде) _____
Орос-Монголын улсын хилийн нэвтрэх гарц (гарахад ороход) _____

Место пребывания в Монголии _____
Монголд байх газар _____

*Действительно только при предъявлении документа, удостоверяющего личность
Зөвхөн биеийн байцаалтын хамт хүчин төгөлдөр байна
Срок пребывания до _____
Байх хугацаа _____

Сопровождаемые дети до 16 лет _____
Дагалдан яваа 16 хүртэл насны хүүхэд _____

(кем выдано удостоверение-должность звание фамилия)
үнэмлэх олгосон албан тушаалтан, цол, нэр

(место и дата выдачи)
үнэмлэх олгосон газар, он, сар, өдөр

(действительно до)
хүчинтэй байх хугацаа

Место печати
Тамга

**МОНГОЛ-ОРОСЫН УЛСЫН ХИЛИЙГ ЦААШ НААШ
НЭГ УДАА НЭВТРЭХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ**

УДОСТОВЕРЕНИЕ

на разовое пересечение монгольской-российской
государственной границы в обе стороны

Овог нэр _____

Фамилия, имя, отчество _____

Монгол оршин суугаа хаяг _____

Местожительство в Монголии _____

Төрсөн он, сар, өдөр _____

Дата рождения _____

Паспорт баримт бичгийн сери, дугаар _____

Серия, номер, документа, удостоверяющего личность _____

Явах зорилго

Албаны

Хувийн

Цель поездки

Служебная

Частная

Уналгын төрөл, тээврийн хэрэгслийн регистрийн

Дугаар _____

Вид транспорта, регистрационный номер транспортного средства _____

Монгол-Оросын улсын хилийн нэвтрэх гарц (гарахад ороход) _____

Пункт пересечения российско-монгольской государственной границы (при выезде и въезде) _____

ОХУ-д байх газар _____

Место пребывания в Российской Федерации _____

*Зөвхөн биеийн байцаалтын хамт хүчин төгөлдөр байна.

Действительно только при предъявлении документа, удостоверяющего личность

Явах маршрут _____

Маршрут следования _____

Дагалдан яваа 16 хүртэл насны хүүхэд _____

Сопровождаемые дети до 16 лет _____

Үнэмлэх олгосон албан тушаалтан, цол, нэр _____

Кем выдано удостоверение-должность звание фамилия _____

Үнэмлэх олгосон газар, он, сар, өдөр _____

Место и дата выдачи _____

Хүртэл хүчинтэй _____

Действительно до _____

Тамга

Место печати

МОНГОЛ-ОРОСЫН УЛСЫН ХИЛИЙГ ХЯЛБАРЧИЛСАН
ЖУРМААР НЭВТРЭХ ЭРХ ОРШИН СУУГЧДАД НЬ
ОЛГОГДСОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ХИЛ ОРЧМЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН
(РАЙОНЫ) ЖАГСААЛТ

1.Бүгд Найрамдах Алтай Улс

Кош-Агачый район

2.Бүгд Найрамдах Тыва улс

Мөнгөн тайгын хошуу

Өвөр хошуу

Тес-Хемийн хошуу

Эрзин хошуу

Тэрхөл хошуу

Каа-Хем хошууны Сизим тосгон (сум)

3.Бүгд Найрамдах Буриад Улс

Окин район

Тункин район

Закамен район

Жидийн район

Хиагтын район

4.Өвөр байгалийн хязгаар

Красночикойн район

Кырийн район

Акшин район

Онон район

Борзын район

МОНГОЛ-ОРОСЫН УЛСЫН ХИЛИЙГ ХЯЛБАРЧИЛСАН
ЖУРМААР НЭВТРЭХ ЭРХ ОРШИН СУУГЧДАД НЬ
ОЛГОГДСОН МОНГОЛ УЛСЫН ХИЛ ОРЧМЫН ЗАСАГ
ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН (СУМДЫН) ЖАГСААЛТ

1.Баян-Өлгий аймаг

Цэнгэл
Улаанхус
Цагааннуур
Ногооннуур
Өлгий

2.Увс аймаг

Бөхмөрөн
Сагил
Давст
Тэс
Зүүнговь
Баруунтуруун

3.Завхан аймаг

Тэс
Баянтэс

4.Хөвсгөл аймаг

Цэцэрлэг
Цагаан-Уул
Баянзүрх
Улаан-Уул
Цагааннуур
Ринчинлхүмбэ
Ханх
Цагаан-Үүр
Эрдэнэбулган
Тариалан

5.Булган аймаг

Тэшиг
Сэлэнгэ

6.Сэлэнгэ аймаг

Түшиг
Цагааннуур
Алтанбулаг
Сүхбаатар
Хүдэр
Ерөө
Баруунбүрэн
Зүүнбүрэн
Сант
Шаамар
Жавхлант
Орхон
Хушаат
Сайхан

7.Хэнтий аймаг

Өмнөдэлгэр
Батширээт
Биндэр
Дадал

8.Дорнод аймаг

Баян-Уул
Баяндун
Дашбалбар
Чулуунхороот